



## ӨВӨРХАНГАЙ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН ЗАХИРАМЖ

2019 оны 12 сарын 18 өдөр

Дугаар 8772

Арвайхээр

Г Нэмэлт ажил гүйцэтгүүлэх гэрээ байгуулах тухай

Барилгын тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.1.2, 35 дугаар зүйлийн 35.1.2 дахь заалт болон Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 34 дүгээр зүйлийн 34.1.4 дэх заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Уянга суманд баригдаж буй 100 хүүхдийн дотуур байрны барилга угсралтын ажлын гүйцэтгэгчээр шалгарсан “Итгэл өргөө” ХХК-ийн гүйцэтгэж буй ажлын тоо хэмжээнд тусгагдаагүй нэгдүгээр давхарын шалны нэмэлт дулаалгын ажил, гадна цэвэр ус хангамж, бетон суурьтай төмөр хашаа, гадна гэрэлтүүлгийн ажлыг нэмэлт ажил гүйцэтгүүлэх гэрээгээр гүйцэтгүүлсүгэй.
2. Нэмэлт гэрээ байгуулж гүйцэтгэлд хяналт тавьж ажиллахыг аймгийн Засаг даргын дэргэдэх Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газар (Ч.Гүнсэнхорол)-д даалгасугай.
3. Нэмэлт ажилд шаардагдах 98.007.514 (ерэн найман сая долоон мянга таван зуун арван дөрөв) төгрөгийг Сангийн яаманд уламжлан тендерийн үнийн зөрүү зардлаас шийдвэрлэхийг аймгийн Засаг даргын Тамгын газрын Санхүү, төрийн сангийн хэлтэс (Д.Нэмэхбаяр)-т зөвшөөрсүгэй.

ЗАСАГ ДАРГА

Г.ГАНБОЛД



011101477

D:My Doc. Zahiramj. Zasag darga